



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/140/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn
Аудитор: П.Амаржаргал
Утас: 88106992 Цахим хаяг: amar_802002@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНЦАГААН СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
ДАРГА М.ЧИНБАТ ТАНАА

2019.02.25 № 2/85
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн

2519156


бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянцагаан сумын Засаг даргын тамгын дарга М.Чинбат-т танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 23-наас 2019 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 2/06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянцагаан сумын ЗДТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянцагаан сумын ЗДТГазар нь “Сум орон нутгаа хөгжүүлэх, нийт ард иргэдэд хууль сурталчилж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж ажиллах, дотоод ажлаа сайжруулах, төлөвлөгөө зорилтоо биелүүлэх, төсвөө үр ашигтай зарцуулахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сум орон нутгаа хөгжүүлж ард иргэддээ хууль сурталчилж, дээд шатны байгууллагуудаас баталж гаргасан хууль тогтоол, заавар журам, дүрмийг баримталж байгууллагын үйл ажиллагааг өндөр түвшинд хангаж ажиллах чиг үүрэгтэй.

Баянцагаан сумын ЗДТГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянцагаан сумын ЗДТГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянцагаан сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Баянцагаан сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянцагаан сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 415.0 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 8,3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд залруулах асуудал гараагүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	3.2	Ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэхгүй байх
	Дүн	1	3.2	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг

Менежментийн захидлаар хүргүүлэв.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянцагаан сумын ЗДТГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 330,4 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 329,7 сая төгрөг буюу 96,5 хувьтай байгаа нь 2018 онд 330,4 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 11,9 сая төгрөг төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянцагаан сумын ЗДТГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянцагаан сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн зарцуулалт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нөөц хөрөнгөөс бэлтгэсэн 3,2 сая төгрөгийн бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 13.4 дэх заалт, сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан НББ-ийн дансны бичилтийн зааврын дагуу хөтлөх Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан журам"-ыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Орлого зарлага дундын тооцоо үүсгэхгүй шууд зардлаар бүртгэх нь зардлын гүйцэтгэл буруу гарах нөлөөтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материал орлого авахдаа шууд зардлаар бүртгэхгүй байх, цаашид холбогдох хууль журмын заалтыг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 04 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>107,590,055.56</u>	<u>67,208,064.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	107,590,055.56	67,208,064.00
351	Түүхий эд материал	1,532,905.00	3,072,905.00
35110	Тусгай зориулалттай материал	1,532,905.00	3,072,905.00
354	Хангамжийн материал	52,446,150.56	19,319,159.00
35410	Бичиг хэргийн материал	1,060,900.00	410,600.00
35420	Аж ахуйн материал	10,381,059.00	17,760,559.00
35450	Барилгын засварын материал	00.00	1,148,000.00
35470	Бусад хангамжийн материал	41,004,191.56	00.00
35600	Мал амьтад	53,611,000.00	44,816,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,294,444,654.20</u>	<u>1,240,501,850.62</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,294,444,654.20	1,240,501,850.62
392	Биет хөрөнгө	1,294,219,654.20	1,226,376,850.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,337,355,547.13	2,017,515,705.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,355,920,338.70	-1,086,860,789.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	127,390,760.00	187,586,204.68
39204	Хуримтлагдсан элэгдэл	-74,946,520.88	-80,475,281.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,288,793.00	106,929,709.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-43,720,600.44	-47,860,016.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,849,152.82	39,469,152.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,723,241.17	-18,103,213.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	116,576,470.00	172,200,830.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-54,409,657.56	-64,526,740.92
39216	Дуусаагүй барилга, байгууламж	150,000,000.00	00.00
39217	Ном	479,290.00	501,290.00
393	Биет бус хөрөнгө	225,000.00	14,125,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,310,000.00	15,210,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,085,000.00	-1,085,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,402,034,709.76</u>	<u>1,307,709,914.62</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>15,833.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	15,833.00
413	Өглөг	00.00	15,833.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	15,833.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,402,034,709.76</u>	<u>1,307,694,081.62</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,402,034,709.76	1,307,694,081.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	384,827,817.78	398,727,817.78
51101	Өмч: - төрийн	384,827,817.78	398,727,817.78
512	Хуримтлагдсан үр дүн	880,164,160.01	697,469,860.60
51210	Өмнөх үеийн үр дүн	880,164,160.01	880,164,160.11
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-182,694,299.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	137,042,731.97	211,496,403.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,402,034,709.76</u>	<u>1,307,709,914.62</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	416,232,766.56	479,197,345.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,465,596.56	82,822,840.00
120	Нийтлэг татварын бус орлого	41,465,596.56	82,822,840.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,465,596.56	82,822,840.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,500.00	673,580.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	41,415,096.56	82,149,260.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	374,767,170.00	396,374,505.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,283,391.00	53,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,283,391.00	53,300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	338,310,443.00	341,121,757.18
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	338,310,443.00	341,121,757.18
1330	Төсвийн захирагчдаас	24,133,800.00	00.00
133003	Хөрөнгийн	24,133,800.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,039,536.00	1,952,748.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,039,536.00	1,952,748.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,131,562,003.83	415,059,146.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,131,562,003.83	415,059,146.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,081,762,187.83	396,016,496.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,054,667.00	164,165,710.00
210101	Үндсэн цалин	159,264,124.00	164,165,710.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,790,543.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,574,155.00	19,925,310.00
210201	Тэтгэврийн даатгал	12,818,011.00	13,365,305.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,442,249.00	1,535,478.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,538,892.00	1,410,694.00
210204	Ажилгүйдлийн даатгал	343,096.00	340,446.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,431,907.00	3,273,387.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,936,488.00	22,942,079.00
210301	Гэрэл, цахилгаан	3,193,618.00	4,641,403.00
210302	Түлш, халаалт	13,742,870.00	18,300,676.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,561,521.00	60,268,231.56
210401	Бичиг хэрэг	2,566,000.00	2,845,300.00
210402	Тээвэр, шатахуун	14,630,656.00	16,193,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,328,100.00	00.00
210404	Ном, хэвлэл	230,500.00	225,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,806,265.00	41,004,191.56
2105	Нормативт зардал	277,800.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	277,800.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,247,848.00	2,635,000.00

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	7,247,848.00	2,635,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,933,000.00	5,177,500.00
210702	Дотоод албан томилолт	6,933,000.00	5,177,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,130,744.00	8,065,903.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,508,334.00	3,499,968.00
210803	Даатгалын үйлчилгээ	436,670.00	722,835.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,000.00	82,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	130,740.00	130,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	832,045,964.83	112,836,762.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,030,596.00	26,831,820.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,525,000.00	187,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	820,490,368.83	85,817,942.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,799,816.00	19,042,650.18
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	2,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,364,236.00	5,697,748.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,039,536.00	1,952,748.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,403,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,921,000.00	3,745,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,460,523.00	11,344,870.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,460,523.00	11,344,870.18
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,975,057.00	32.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,975,057.00	32.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-715,329,237.27	64,138,198.50
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	246,832,498.01
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	3,799,999.96
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	150,000,000.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	93,032,498.05
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-715,329,237.27	182,694,299.51

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	350,683,870.00	397,048,085.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,500.00	673,580.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,500.00	673,580.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,500.00	673,580.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,500.00	673,580.00

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	350,633,370.00	396,374,505.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,283,391.00	53,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,283,391.00	53,300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	338,310,443.00	341,121,757.18
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	338,310,443.00	341,121,757.18
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,039,536.00	1,952,748.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,039,536.00	1,952,748.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	350,683,870.00	288,843,379.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,683,870.00	288,843,379.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	300,884,054.00	269,726,729.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,054,667.00	164,149,877.00
210101	Үндсэн цалин	159,264,124.00	164,149,877.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,790,543.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,574,155.00	19,925,310.00
210201	Тэтгэврийн даатгал	12,818,011.00	13,365,305.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,442,250.00	1,535,478.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,571,630.00	1,410,694.00
210204	Ажилгүйдлийн даатгал	375,836.00	340,446.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,366,428.00	3,273,387.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,936,488.00	24,090,079.00
210301	Гэрэл, цахилгаан	3,193,618.00	5,789,403.00
210302	Түлш, халаалт	13,742,870.00	18,300,676.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,749,056.00	18,613,740.00
210401	Бичиг хэрэг	3,239,800.00	2,195,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,630,656.00	16,193,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,628,100.00	00.00
210404	Ном, хэвлэл	250,500.00	225,500.00
2105	Нормативт зардал	277,800.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	277,800.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,976,748.00	10,014,500.00
210602	Тавилга	8,695,900.00	380,000.00
210604	Урсгал засвар	7,280,848.00	9,634,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,933,000.00	5,177,500.00
210702	Дотоод албан томилолт	6,933,000.00	5,177,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,332,544.00	8,065,903.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,710,134.00	3,499,968.00
210803	Даатгалын үйлчилгээ	436,670.00	722,835.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,000.00	82,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	130,740.00	130,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,049,596.00	19,689,820.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,524,596.00	19,502,820.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,525,000.00	187,000.00

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,799,816.00	19,116,650.18
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	2,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,364,236.00	5,771,748.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,039,536.00	1,952,748.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,403,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,921,000.00	3,819,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,460,523.00	11,344,870.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,460,523.00	11,344,870.18
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,975,057.00	32.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,975,057.00	32.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	108,204,706.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	108,204,706.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	108,204,706.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	108,204,706.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	108,204,706.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-108,204,706.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	384,827,817.78	137,042,731.97	880,164,160.01	00.00	1,402,034,709.76
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	384,827,817.78	137,042,731.97	880,164,160.01	00.00	1,402,034,709.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.10	00.00	00.10
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	384,827,817.78	137,042,731.97	880,164,160.11	00.00	1,402,034,709.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	74,453,671.27	00.00	00.00	74,453,671.27
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	13,900,000.00	00.00	00.00	00.00	13,900,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-182,694,299.51	00.00	-182,694,299.51
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,727,817.78	211,496,403.24	697,469,860.60	00.00	1,307,694,081.62

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	338,910,200.00	324,900,420.00	341,721,933.20	330,450,467.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	338,910,200.00	324,900,420.00	341,721,933.20	330,450,467.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	311,707,500.00	298,575,720.00	282,244,433.20	273,468,761.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,282,200.00	171,054,667.00	170,919,345.00	164,149,877.00
210101	Үндсэн цалин	163,424,000.00	159,264,124.00	170,919,345.00	164,149,877.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,858,200.00	11,790,543.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,469,100.00	19,574,155.00	20,609,015.00	19,925,310.00
210201	Тэтгэврийн даатгал	20,469,100.00	12,818,011.00	16,834,640.00	13,365,305.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,442,250.00	944,100.00	1,535,478.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,571,630.00	755,100.00	1,410,694.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	375,836.00	189,000.00	340,446.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,366,428.00	1,886,175.00	3,273,387.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,025,400.00	16,936,488.00	24,175,896.00	24,090,079.00
210301	Гэрэл, цахилгаан	3,194,900.00	3,193,618.00	5,828,200.00	5,789,403.00
210302	Түлш, халаалт	13,830,500.00	13,742,870.00	18,347,696.00	18,300,676.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,326,500.00	20,749,056.00	19,002,300.00	18,635,740.00
210401	Бичиг хэрэг	3,222,000.00	3,239,800.00	2,233,600.00	2,195,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,666,000.00	14,630,656.00	16,259,500.00	16,193,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,853,600.00	2,628,100.00	00.00	00.00
210404	Ном, хэвлэл	584,900.00	250,500.00	509,200.00	247,500.00
2105	Нормативт зардал	278,100.00	277,800.00	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	278,100.00	277,800.00	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,990,000.00	15,976,748.00	17,257,500.00	17,234,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	2,600,000.00	2,600,000.00
210602	Тавилга	8,700,000.00	8,695,900.00	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	7,290,000.00	7,280,848.00	9,657,500.00	9,634,500.00
2107	Томилолт, зочны зардал	7,826,000.00	6,933,000.00	5,550,800.00	5,177,500.00
210702	Дотоод албан томилолт	7,826,000.00	6,933,000.00	5,550,800.00	5,177,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,233,500.00	34,024,210.00	5,026,700.00	4,565,935.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,403,000.00	33,401,800.00	449,940.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	436,670.00	600,000.00	722,835.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,500.00	55,000.00	180,000.00	82,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	00.00	102,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	3,564,000.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	90,000.00	130,740.00	130,760.00	130,700.00

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,276,700.00	13,049,596.00	19702877.20	19689820.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,751,700.00	11,524,596.00	19,503,877.20	19,502,820.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,525,000.00	1,525,000.00	199,000.00	187,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,202,700.00	26,324,700.00	59477500.00	56981706.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	54,040,500.00	53,162,706.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	54,040,500.00	53,162,706.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,202,700.00	26,324,700.00	5,437,000.00	3,819,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,403,700.00	18,403,700.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,799,000.00	7,921,000.00	5,437,000.00	3,819,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	338,910,319.00	324,900,420.00	341,721,933.20	330,450,467.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	338,310,319.00	324,849,920.00	341,721,933.20	329,776,887.00
132001	Орон нутгийн төсвөөс	338,310,319.00	324,849,920.00	341,721,933.20	329,776,887.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	600,000.00	50,500.00	00.00	673,580.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	50,500.00	00.00	673,580.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	13.00	13.00	13.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	07.00	07.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	05.00	05.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	05.00	05.00	07.00	07.00
650010	Гэрээт ажилтан	04.00	04.00	00.00	00.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	05.00	05.00	07.00	07.00